



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 5.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын төлөөлөн удирдах зөвлөлд төрийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Баяр-Эрдэнэ -Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Ч.Золбаяр -Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайдын зөвлөх (зөвшилцсөнөөр)

Т.Лхагвасүрэн -Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

А.Молор -Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Г.Нямдаваа -Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Амарбаясгалан -Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга

Д.Дариймаа -Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалтыг холбогдох журамд заасны дагуу зохион байгуулж тайланг танилцуулахыг Ажлын хэсгийн дарга /Ц.Баяр-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132013546

ТӨБЗГ тушаал-/2023